



САНХҮҮГИЙН АУДИТЫН ТАЙЛАН

Баян-Овоо сумын ИТХурлын 2018 оны санхүүгийн тайлан,
төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

Аудитын код: БНА-2019/92/СТА-ТШЗ

Цахим хуудас: www.audit.mn

Баянхонгор хот 2019 он

Тэргүүлэх аудитор: Б.Мөнхбат

Утас: 99007576

Цахим хаяг: munkhbatb@audit.gov.mn

Аудитын менежер: Д.Цэцэгмаа

Утас: 88089024

Цахим хаяг: tsetsegmaadam@audit.gov.mn

Аудитор:

Б.Азбаяр

Утас: 99061429

Цахим хаяг: azbayarb@audit.gov.mn

Товчилсон үгийн жагсаалт

УСНББОУС	Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт
АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
АОУС	Аудитын Олон Улсын Стандарт

Агуулга

1	Аудитын гэрчилгээ.....	3
2	Аудитын тайлан	5
2.1.	Оршил	5
2.2.	Аудит хийх үндэслэл, зорилго, талуудын хүлээх үүрэг, хариуцлага	5
2.3.	Аудитын явцад мөрдсөн бодлого, журам, арга зүй, шалгуур үзүүлэлт	5
2.4.	Байгууллагын зорилго, үйл ажиллагаа, хууль, эрх зүйн орчин.....	6
2.5.	Нягтлан бодох бүртгэлийн бодлого, үйл ажиллагаа болон дотоод хяналттай холбоотой хүчин зүйлсийн үнэлгээ	7
2.6.	Төлөвлөлтийн шатанд тодорхойлсон эрсдэл, түүнийг үнэлсэн байдал	7
2.7.	Материаллаг байдлын суурь сонгосон үндэслэл, тайлбар.....	8
2.8.	Аудитын явцад хэрэгжүүлсэн горим сорил, түүний үр дүн.....	8
2.8.1.	Зөвлөмж өгөхөөс бусад хэлбэрээр шийдвэрлэсэн алдаа, зөрчилтэй асуудал байхгүй.....	8
2.9.	Дараагийн аудитаар авч үзэх буюу анхаарал татахуйц бусад чухал асуудал.....	8
2.10.	Төсвийн гүйцэтгэлийн талаарх тайлбар, тодруулга	9
2.11.	Шилэн дансны мэдээлэл.....	9
2.12.	Өмнөх зөвлөмжийн хэрэгжилтийн талаарх тайлбар, тодруулга	9
2.13.	Санал дүгнэлтийн хэлбэр, үндэслэл.....	9
3	Аудит хийсэн санхүүгийн тайлан.....	10
3.1	Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан.....	10
3.2	Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан	11
3.3	Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан.....	12
3.4	Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан.....	13
3.5	Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан.....	13

1 Аудитын гэрчилгээ



**БАЯНХОНГОР АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**

64101 Номгон, Баянхонгор сум
Утас, факс 70-44-25-84
E-mail: bayankhongor@audit.gov.mn

2019.02.20 № 2/20

танай _____-ны № _____-т

Аудитын гэрчилгээ

Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1, 18 дугаар зүйлийн 18.2, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-т заасны дагуу Баян-Овоо сумын ИТХ-ын 2018 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд санхүүгийн тайлангийн аудит хийв.

Зөрчилгүй санал дүгнэлт

Баян-Овоо сумын ИТХ-ын 2018 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээ бо лон төсвийн гүйцэтгэлийн тайланг материаллаг зүйлсийн хувьд Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, УСНББОУС-д нийцүүлж, Сангийн сайдын баталсан бодлого, журам, зааврын дагуу үнэн, бодитой, шударга илэрхийлсэн тул зөрчилгүй санал дүгнэлт гаргаж байна.

Санал дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагуудын нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчим, стандарт болон Аудитын олон улсын стандартад нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан Санхүүгийн тайлангийн аудитын журам, зааврын дагуу гүйцэтгэсэн. Эдгээр нь санхүүгийн тайлан материаллаг буруу илэрхийллээс ангид эсэх талаар үндэслэлтэй баталгаа олж авах зорилгоор аудитыг төлөвлөж, гүйцэтгэхийг шаарддаг.

Аудитаар Баян-Овоо сумын ИТХ-ын 2018 оны жилийн эцсийн төсвийн гүйцэтгэл, санхүүгийн тайлан дахь үлдэгдэл, ажил гүйлгээний дүн хэмжээ болон илчлэл тодруулга, тус байгууллагад мөрдөж байгаа нягтлан бодох бүртгэлийн бодлого, бүртгэлийн хөтлөлт, програм хангамж, дотоод хяналтын систем болон удирдлагын хийсэн томоохон тооцооллыг шалгаж, аудитын санал дүгнэлтийг дэмжих нотлох зүйлсийг хангалттай цуглуулсан.

2519006

E:\ajil\2019 on\STA 2018\5.Bayan-owoo ITH\4.Tailagnal\Аудитын гэрчилгээ.docx

Бидний хийсэн аудит тус санхүүгийн тайлан, тодруулгад санал дүгнэлт өгөх хангалттай, зохистой үндэслэлийг бүрдүүлсэн бөгөөд аудитын дүнд үндэслэсэн санал, зөвлөмжийг аудитын тайланд тусгасан болно.

Үүрэг хариуцлага

Төсвийн захирагч нь Төсвийн тухай хуулийн 26 дугаар зүйлийн 26.1-т заасны дагуу тайлант хугацааны санхүүгийн тайлан, тодруулгыг Нягтлан бодох бүртгэлийн болон Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт, түүнтэй нийцүүлэн Сангийн сайдын баталсан журам, зааврын дагуу бэлтгэж тайлагнах үүрэгтэй.

Аудитын дээд байгууллагуудын нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчим, стандарт болон Аудитын олон улсын стандартын дагуу аудитын хийж, жилийн эцсийн төсвийн гүйцэтгэл, санхүүгийн тайланд санал дүгнэлт өгөх нь төрийн аудитын байгууллагын үүрэг юм.

ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Б.МӨНХБАТ

2 Аудитын тайлан

2.1. Оршил

Баян-Овоо сумын ИТХ-ын 2018 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын дүн, дүгнэлтийг нарийн бичгийн дарга Д.Эрдэнэбулганд танилцуулж байна.

Энэхүү тайланд үйлчлүүлэгчийн санхүү, нягтлан бодох бүртгэл, дотоод хяналтын системд хийсэн үнэлгээний тойм, аудитын явцад илрүүлсэн гол зүйлс, гаргасан шийдлүүд, анхаарал хандуулахуйц залруулаагүй материаллаг болон материаллаг бус алдаа зөрчлийн талаарх тайлбар, тодруулга зэрэг аудитын үр дүнгийн талаарх тайлбар, тодруулга, аудитын санал дүгнэлтийн хэлбэр, түүний үндэслэлийн талаар тус тус хураангуйлан тэмдэглэв.

Дараагийн заалтад аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайланг батлагдсан ангилал, үзүүлэлтээр бэлтгэж оруулав.

2.2. Аудит хийх үндэслэл, зорилго, талуудын хүлээх үүрэг, хариуцлага

Бид Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1, 15.2, 18 дугаар зүйлийн 18.2, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Баян-Овоо сумын ИТХ-ын 2018 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болгосон санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Баян-Овоо сумын ИТХ-ын 2018 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль болон УСНББОУС, түүнд нийцүүлэн гаргасан төсвийн байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлого, заавар, журмын дагуу үнэн зөв, шударга илэрхийлэгдсэн эсэхэд дүгнэлт өгөх нь энэхүү аудитын зорилт байв.

Төсвийн шууд захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайлангаа Төсвийн тухай хууль болон УСНББОУС, түүнд нийцүүлэн баталсан төсвийн байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлого, журмын дагуу үнэн зөв, бодитой бэлтгэх үүрэгтэй.

Харин тухайн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг дээрх хууль болон бодлого, журмын дагуу материаллаг алдаагүй, үнэн зөв, шударга илэрхийлсэн эсэхэд санал дүгнэлт өгөх нь Төрийн аудитын байгууллагын үүрэг юм.

Аудитыг 2019.01.25-наас 2019.02.20-ны хооронд гүйцэтгэж, аудитын тайланг 2019.02.20-ны өдөр эцэслэн баталгаажуулж, Төсвийн захирагчид хүргүүлэхээр төлөвлөн, Баянхонгор аймаг дахь төрийн аудитын газрын аудитор Б. Азбаяр хариуцаж хэрэгжүүлэв.

Баян-Овоо сумын ИТХ-ын 2018 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайланг Баянхонгор аймаг дахь төрийн аудитын газарт 2019.01.21-ны өдрийн № 03 дугаар бүхий албан бичгээр ирүүлсэн байна.

2.3. Аудитын явцад мөрдсөн бодлого, журам, арга зүй, шалгуур үзүүлэлт

Аудитын явцад АДБОУС, АОУС, нийтээр хүлээн зөвшөөрсөн бусад зарчимд тулгуурласан төрийн аудитын байгууллагын санхүүгийн тайлангийн аудитын талаарх бодлого, арга зүйг мөрдөж ажиллав.

Дээрх стандарт, зарчимд нийцүүлж Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан Төрийн аудитын байгууллагаас санхүүгийн тайланд аудит хийх журам, түүнд тусгасан үе шатны ажлыг гүйцэтгэж, холбогдох ажлын баримт материалаар баталгаажуулсан болно.

Аудитын үйл явц, үр дүнг АДБООУС, АООУС-ын дагуу шат шатны чанарын хяналт хийж баталгаажуулсан болно.

Аудитыг дээрх бодлого, арга зүйд нийцүүлэн төлөвлөлтийн шатанд баталсан аудитын төлөвлөгөө, хөтөлбөрийн дагуу явуулав.

Аудит хийхэд Нягтлан бодох бүртгэлийн нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчмууд, УСНБООУС, Төсвийн тухай хууль болон Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийг гол шалгуур болголоо.

2.4. Байгууллагын зорилго, үйл ажиллагаа, хууль, эрх зүйн орчин

Бид аудитын төлөвлөгөө, хөтөлбөрийн дагуу байгууллагын үйл ажиллагаа, түүний гадаад дотоод орчны талаар шаардлагатай хэмжээнд судалж, тэдгээрийн үр дүнг аудитад ашигласан.

Баян-Овоо сумын ИТХ-ын талаарх ерөнхий мэдээллийг аудитыг төлөвлөх үе шатанд шинэчлэн баримтжуулж, А101 маягтаар баталгаажуулсан болно.

Эрхэм зорилго:

“Нутгийн өөрөө удирдах байгууллагын хууль ёсоо дээдлэн, ил тод байдлыг хангасан, сумын хөгжлийн бодлогыг иргэдийн эрх ашигт нийцүүлэн оновчтой тодорхойлон хэрэгжилтийг хангуулж, иргэдийн эрх чөлөөтэй, ая тухтай ажиллаж амьдрах нөхцөл боломжоор хангах” гэсэн эрхэм зорилгын дор үйл ажиллагааны чиглэл зорилтоо тодорхойлон ажиллажээ.

Үйл ажиллагааны чиглэл:

Бага дунд боловсролын тухай хуулийн дагуу Баян-Овоо сумын ИТХ-ын үйл ажиллагааны чиглэлийг дараах байдлаар тодорхойлжээ. Үүнд:

- Нутгийн өөрөө удирдах байгууллагын үйл ажиллагаанд зохион байгуулалтыг боловсронгуй болгож хурлын байгууллагаас хэрэгжүүлж буй ажилд иргэдийн оролцоог нэмэгдүүлнэ.
- Сумын эдийн засаг, нийгмийг хөгжүүлэх бодлого төлөвлөлтийг оновчтой болгож салбаруудын чиглэлээр дэд хөтөлбөр гарган хэрэгжилтийг хангуулах ажлыг зохион байгуулж хэрэгжүүлнэ.
- Сумын хурлын төлөөлөгч, сонгогч иргэдийн харилцаа холбоог сайжруулна.
- Иргэдийн оролцоонд тулгуурласан Иргэдийн төлөөлөгчдийн хурлын хяналтын тогтолцоог сайжруулна.

Баян-Овоо сумын ИТХ-ын үндсэн болон үндсэн бус үйл ажиллагааны талаар төлөвлөлтийн шатанд судалж, баримтжуулсан.

Баян-Овоо сумын ИТХ-ын удирдлага төсвийн шууд захирагчийн хувьд дараах хууль болон УСНБООУС, түүнд нийцүүлэн баталсан төсвийн байгууллагын Нягтлан

бодох бүртгэлийн бодлого, журмын хүрээнд төсөв, санхүү, нягтлан бодох бүртгэлийн үйл ажиллагааг эрхлэн гүйцэтгэж байна. Үүнд:

- Төсвийн тухай хууль
- Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль
- Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хууль
- Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хууль
- Шилэн дансны тухай хууль
- Монгол Улсын 2018 оны Төсвийн тухай хууль
- Монгол улсын засаг захиргааны нэгж түүний удирдлагын тухай хууль

Тайлант хугацаанд дээрх бодлого, журамд томоохон шинэчлэлт, өөрчлөлт гараагүй байна.

2.5. Нягтлан бодох бүртгэлийн бодлого, үйл ажиллагаа болон дотоод хяналттай холбоотой хүчин зүйлсийн үнэлгээ

Бид санхүүгийн тайланд материаллаг алдаа байхгүй гэдгийг нягтлах үүднээс үйлчлүүлэгчийн нягтлан бодох бүртгэлийн бодлого, үйл ажиллагаа болон дотоод хяналтыг шаардлагатай гэж үзсэн хэмжээгээр дахин хянасан. Энэ нь материаллаг алдаа гарахаас хамгаалах ёстой гол бодлого, хяналтуудыг тодруулах, судлах зорилготой юм.

Тус газрын одоо мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг Сангийн яамнаас авч хэрэгжүүлж байгаа нягтлан бодох бүртгэлийн бодлогын шинэчлэлт, холбогдох стандарт, хууль тогтоомжтой нийцтэй байгаа эсэхийг судалж үзэхэд шинээр батлагдсан бодлого, журамд нийцсэн байна.

Баян-Овоо сумын ИТХ-ын санхүү, нягтлан бодох бүртгэлийн үйл ажиллагаанд ашиглаж байгаа мэдээллийн технологи, бүртгэл мэдээллийн системийн үйл ажиллагаатай танилцан түүний нарийн түвэгтэй байдлыг үнэлэхэд мэдээллийн технологийн мэргэжилтнийг аудитад татан оролцуулах шаардлагагүй гэж үзсэн тул аудитыг томилогдсон аудитор гүйцэтгэлээ.

Баян-Овоо сумын ИТХ-ын санхүүгийн тайланг бэлтгэхдээ нягтлан бодох бүртгэлийн “Санхүүгийн тооцоолох” ХХК-ийн “Acolous” программ хангамж ашигладаг байна.

Баян-Овоо сумын ИТХ-ын дотоод хяналтын эрсдэлийг төлөвлөлтийн үе шатанд “дунд” гэж үнэлсэн бөгөөд гүйцэтгэлийн шатанд дахин хянахад дотоод хяналт үр нөлөөтэй гэж үзлээ.

2.6. Төлөвлөлтийн шатанд тодорхойлсон эрсдэл, түүнийг үнэлсэн байдал

Аудитын явцад Баян-Овоо сумын ИТХ-ын бэлтгэсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл нь материаллаг хэмжээний алдаатай илэрхийлэгдээгүй гэсэн үндэслэлтэй нотолгоо олж авахын тулд байгууллагын гадаад дотоод орчин, дотоод хяналтыг судалж, санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайлантай холбоотой эрсдэлтэй асуудлыг илрүүлж, үнэлсэн.

Аудитыг төлөвлөх үе шатанд эрсдэлийн үнэлгээний урьдчилсан горим хэрэгжүүлэн 7 эрсдэлтэй асуудал тодорхойлж, эрсдэлийн үнэлгээний дүнд үндэслэн асуудалд нарийвчилсан горим сорил хэрэгжүүлэхээр төлөвлөж баталгаажуулсан болно.

Аудитын чиглэл тус бүрд хамаарах илрүүлсэн эрсдэлийн жагсаалт, түүний үнэлгээг Б301 маягтаар, эрсдэлтэй асуудлыг сорих аудитын горим, сорил, түүнийг баримтжуулах, нотлох зүйлс цуглуулах арга зүйг Б401, Б402 маягтаар тус тус баримтжуулав.

2.7. Материаллаг байдлын суурь сонгосон үндэслэл, тайлбар

Аудитыг төлөвлөх болон гүйцэтгэх үе шатны материаллаг байдлыг АДБОУС 1320, АОУС 320-ын дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр Нийт зардлын 2 хувиар сонгов.

Гүйцэтгэлийн үе шатанд материаллаг байдлын үзүүлэлтийг үр дүнгийн тайлангийн нийт зардлаар сонгосон ба аккруэль сууриар бэлтгэгдсэн санхүүгийн тайлангийн хувьд дээрх үзүүлэлтийг суурь болгож авах нь зүйтэй гэж үзлээ.

Баян-Овоо сумын ИТХ-ын 2018 оны Нийт зардал 192316,2 мянган төгрөг бөгөөд түүний 2 хувь болох 3846,2 мянган төгрөгөөр материаллаг байдлыг тодорхойлж, баталгаажууллаа.

Материаллаг байдлыг суурь үзүүлэлтээс тооцох хувийг 2 хувиар тооцсон нь эрсдэлийн түвшин дунд байгаатай холбоотой юм.

Аудитыг төлөвлөх үе шатны материаллаг байдлын түвшинг Б201, аудитыг гүйцэтгэх үе шатны материаллаг байдлын түвшинг В401 маягтаар тус тус баримтжуулан баталгаажуулав.

2.8. Аудитын явцад хэрэгжүүлсэн горим сорил, түүний үр дүн

Аудитыг төлөвлөх үе шатанд тогтоосон эрсдэл тус бүрд хэрэгжүүлэхээр төлөвлөсөн горим сорилын хэрэгжилт, гол үр дүнгийн талаар дор нэгтгэн тэмдэглэв.

Эрсдэлийн үнэлгээний дүнд үндэслэн аудитын 5 чиглэлээр аудитын 6 горим сорил гүйцэтгэж, үнэлэхэд алдаа зөрчилтэй асуудал гараагүй.

Аудитын явцад залруулга хийгдээгүй байна.

Аудитын явцад илрүүлсэн залруулаагүй алдаа, зөрчилтэй асуудал гараагүй.

2.8.1. Зөвлөмж өгөхөөс бусад хэлбэрээр шийдвэрлэсэн алдаа, зөрчилтэй асуудал байхгүй

2.9. Дараагийн аудитаар авч үзэх буюу анхаарал татахуйц бусад чухал асуудал

байхгүй

2.10. Төсвийн гүйцэтгэлийн талаарх тайлбар, тодруулга

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь энэ хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

Төрийн аудитын байгууллага санхүүгийн тайлангийн аудитаар төсвийн шууд захирагч нь батлагдсан төсөв, түүний гүйцэтгэлийг зохих журмын дагуу зохион байгуулсан, үнэн зөв, тайлагнасан эсэхэд үнэлэлт өгөхийг зорьдог.

Баян-Овоо сумын ИТХ-ын чиг үүргээ хэрэгжүүлэхтэй нь холбоотой хөтөлбөр, арга хэмжээнд зориулан 2018 онд 49679.9 мянган төгрөгийн төсөв батлагджээ. Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийн талаарх дэлгэрэнгүй мэдээллийг энэ тайлангийн 4.5-д дэлгэрэнгүй харуулав.

Төсвийн зардлын нийт гүйцэтгэл 48875.5 мянган төгрөг буюу 98.4 хувьтай байгаа бөгөөд нийт батлагдсан төлөвлөгөөнөөс 807.3 мянган төгрөгийн санхүүжилт дутуу ирсэн байна.

2.11. Шилэн дансны мэдээлэл

Баян-Овоо сумын ИТХ-ын Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан мэдээллийг өөрийн цахим хуудсаар дамжуулан тухай бүр ил тод мэдээлж байх үүрэгтэй.

Шилэн дансны тухай хуулийн дагуу тогтоосон хугацаанд мэдээлбэл зохих 25 мэдээнээс 19 мэдээг хугацаандаа 5 мэдээг хугацаа хоцорч мэдээлсэн 1 мэдээг мэдээлээгүй байна. 7 хоногийн дотор мэдээлбэл зохих 18.0 сая төгрөгийн 3 гүйлгээг цахим сайтад байршуулжээ.

Тус байгууллагын Шилэн дансны хуулиар хүлээсэн үүргийн биелэлтийг төлөвлөсөн хэмжээнд хянаж, баримтжуулсан болно.

2.12. Өмнөх зөвлөмжийн хэрэгжилтийн талаарх тайлбар, тодруулга

Өмнөх санхүүгийн тайлангийн аудитаар зөвлөмж өгөөгүй байна.

Эдгээр зөвлөмжийн биелэлтийн талаарх мэдээллийг ажлын баримт материалд хадгалсан бөгөөд гүйцэтгэлийг аудитын явцад дахин нягталсан болно.

2.13. Санал дүгнэлтийн хэлбэр, үндэслэл

Бид Баян-Овоо сумын ИТХ-ын 2018 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайланд аудит хийж, баталгаажуулах ажлыг АДБОУС-ын дагуу, Монгол Улсын холбогдох хууль тогтоомжид нийцүүлэн гүйцэтгэсэн.

Баян-Овоо сумын ИТХ-ын 2018 оны жилийн эцсийн санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, мөнгөн гүйлгээ, өмчийн өөрчлөлтийн болон бусад илчлэл тодруулгад тайлагнасан үлдэгдэл, ажил гүйлгээнүүдээ холбогдох хууль, УСНББОУС, түүнд нийцүүлэн Сангийн сайдын баталсан заавар, журмуудын дагуу материаллаг байдлын хувьд алдаагүй, үнэн зөв, шударга илэрхийлсэн эсэхийг Аудитын гэрчилгээнд тодорхой дурдав.

Аудитын гэрчилгээг энэ тайлангийн 1 дүгээр хэсэгт үзүүлэв.

3 Аудит хийсэн санхүүгийн тайлан

3.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

Дансны код	Балансын үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	<u>695,730.52</u>	<u>820,000.00</u>
33	АВЛАГА	94,970.52	00.00
33100	Ажиллагчидтай холбогдсон авлага	94,970.52	00.00
35	БАРАА МАТЕРИАЛ	600,760.00	820,000.00
354	Хангамжийн материал	600,760.00	820,000.00
35410	Бичиг хэргийн материал	320,760.00	20,000.00
35420	Аж ахуйн материал	280,000.00	800,000.00
2	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	<u>175,494,870.49</u>	<u>35,847,358.72</u>
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	175,494,870.49	35,847,358.72
392	Биет хөрөнгө	175,209,870.49	35,847,358.72
39201	Барилга, байгууламж, орон сууц	20,000,000.00	00.00
39203	Авто-тээврийн хэрэгсэл	46,980,392.00	46,000,000.00
39204	Хуримтлагдсан элэгдэл	-18,230,392.03	-24,916,666.71
39205	Машин тоног төхөөрөмж (компьютер)	32,730,430.00	27,870,000.00
39206	Хуримтлагдсан элэгдэл	-18,077,475.72	-18,856,637.84
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	7,639,978.00	9,725,575.00
39208	Хуримтлагдсан элэгдэл	-3,443,561.50	-3,974,911.74
39214	Бусад үндсэн хөрөнгө	125,242,500.00	4,620,000.00
39215	Хуримтлагдсан элэгдэл	-17,632,000.26	-4,619,999.99
393	Биет бус хөрөнгө	285,000.00	00.00
39303	Бусад биет бус хөрөнгө	285,000.00	00.00
3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II	<u>176,190,601.01</u>	<u>36,667,358.72</u>
4	НИЙТ ӨР ТӨЛБӨР	<u>83,200.00</u>	<u>00.00</u>
41	БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР	83,200.00	00.00
413	Өглөг	83,200.00	00.00
4136	Бусад өглөг	83,200.00	00.00
41361	Байгууллагад төлөх өглөг	29,200.00	00.00
41362	Хувь хүмүүст төлөх өглөг	54,000.00	00.00
5	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	<u>176,107,401.01</u>	<u>36,667,358.72</u>
51	Засгийн газрын хувь оролцоо	176,107,401.01	36,667,358.72
511	Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан	5,101,612.00	5,101,612.00
51101	Өмч: - төрийн	5,101,612.00	5,101,612.00
512	Хуримтлагдсан үр дүн	169,993,510.83	30,553,468.54
51210	Өмнөх үеийн үр дүн	169,993,510.83	169,993,510.83
51220	Тайлант үеийн үр дүн	00.00	139,440,042.29
51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	1,012,278.18	1,012,278.18
6	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V	<u>176,190,601.01</u>	<u>36,667,358.72</u>

Баян-Овоо сумын ИТХ-ын 2018 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

3.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)	22,306,334.00	52,876,200.00
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	22,306,334.00	52,876,200.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	00.00	4,000,000.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	00.00	4,000,000.00
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих	21,277,000.00	48,876,200.00
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	21,277,000.00	48,876,200.00
1340	Нийгмийн даатгалын сангийн төсвөөс санхүүжих	1,029,334.00	00.00
134001	Нийгмийн даатгалын сангаас санхүүжих	1,029,334.00	00.00
2	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	31,316,940.29	79,772,117.62
21	УРСГАЛ ЗАРДАЛ	31,316,940.29	79,772,117.62
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	30,287,606.29	79,771,428.61
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	16,457,926.03	36,897,627.52
210101	Үндсэн цалин	16,457,926.03	36,897,627.52
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	1,822,971.64	4,439,783.99
210201	Тэтгэврийн даатгал	1,822,971.64	2,977,964.12
210202	Тэтгэмжийн даатгал	00.00	346,020.75
210203	ҮОМШӨ-ний даатгал	00.00	309,288.64
210204	Ажилгүйдлийн даатгал	00.00	73,110.40
210205	Эрүүл мэндийн даатгал	00.00	733,400.08
2104	Хангамж, бараа материалын зардал	581,200.00	2,262,330.00
210401	Бичиг хэрэг	371,500.00	1,493,030.00
210402	Тээвэр, шатахуун	183,200.00	669,300.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	00.00	100,000.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	26,500.00	00.00
2105	Нормативт зардал	00.00	4,000,000.00
210502	Хоол, хүнс	00.00	4,000,000.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	187,340.00	832,900.00
210604	Урсгал засвар	187,340.00	832,900.00
2107	Томилолт, зочны зардал	182,000.00	1,027,500.00
210702	Дотоод албан томилолт	182,000.00	1,027,500.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	11,056,168.62	30,311,287.10
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	00.00	608,000.00
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	11,056,168.62	29,703,287.10
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	1,029,334.00	689.01
2132	Бусад урсгал шилжүүлэг	1,029,334.00	00.00
213202	Нийгмийн даатгалын тэтгэвэр, тэтгэмж	1,029,334.00	00.00
2135	Төсвийн захирагчдаас олгосон санхүүжилт, шилжүүлэг	00.00	689.01
213503	Төвлөрүүлэх шилжүүлэг	00.00	689.01
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)	-9,010,606.29	-26,895,917.62
225	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН	00.00	112,544,124.67
225005	Үнэ төлбөргүй гарсан зардал	00.00	112,544,124.67
4	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ҮР ДҮН (4)=(145-225)	00.00	-112,544,124.67
5	НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)	-9,010,606.29	-139,440,042.29

Баян-Овоо сумын ИТХ-ын 2018 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

3.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ		
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)	46,801,202.00	52,876,200.00
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	190,000.00	00.00
120	Нийтлэг татварын бус орлого	190,000.00	00.00
120009	Бусад орлого	190,000.00	00.00
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	46,611,202.00	52,876,200.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	1,000,000.00	4,000,000.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	1,000,000.00	4,000,000.00
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих	43,720,100.00	48,876,200.00
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	43,720,100.00	48,876,200.00
1340	Нийгмийн даатгалын сангийн төсвөөс санхүүжих	1,891,102.00	00.00
134001	Нийгмийн даатгалын сангаас санхүүжих	1,891,102.00	00.00
2	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)	46,801,202.00	52,876,200.00
21	УРСГАЛ ЗАРДАЛ	46,801,202.00	52,876,200.00
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	44,060,409.70	52,875,510.99
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	35,255,764.00	36,846,140.99
210101	Үндсэн цалин	31,708,311.00	33,723,645.95
210104	Урамшуулал	3,547,453.00	3,122,495.04
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	3,944,345.70	4,479,500.00
210201	Тэтгэврийн даатгал	3,944,345.70	2,986,200.00
210202	Тэтгэмжийн даатгал	00.00	373,300.00
210203	ҮОМШӨ-ний даатгал	00.00	298,700.00
210204	Ажилгүйдлийн даатгал	00.00	74,700.00
210205	Эрүүл мэндийн даатгал	00.00	746,600.00
2104	Хангамж, бараа материалын зардал	1,626,800.00	1,548,700.00
210401	Бичиг хэрэг	767,600.00	450,480.00
210402	Тээвэр, шатахуун	559,200.00	669,300.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	300,000.00	428,920.00
2105	Нормативт зардал	525,000.00	00.00
210502	Хоол, хүнс	525,000.00	00.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	1,007,000.00	3,973,920.00
210601	Багаж, техник, хэрэгсэл	00.00	2,649,900.00
210604	Урсгал засвар	1,007,000.00	1,324,020.00
2107	Томилолт, зочны зардал	439,000.00	1,027,500.00
210702	Дотоод албан томилолт	439,000.00	1,027,500.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	1,000,000.00	4,000,000.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	1,000,000.00	4,000,000.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	262,500.00	999,750.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	262,500.00	999,750.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	2,740,792.30	689.01
2132	Бусад урсгал шилжүүлэг	2,491,102.00	00.00
213202	Нийгмийн даатгалын тэтгэвэр, тэтгэмж	1,891,102.00	00.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	600,000.00	00.00
2134	Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт	249,690.30	00.00
213403	Төвлөрүүлэх шилжүүлэг	249,690.30	00.00
2135	Төсвийн захирагчдаас олгосон санхүүжилт, шилжүүлэг	00.00	689.01
213503	Төвлөрүүлэх шилжүүлэг	00.00	689.01
7	САНХҮҮГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ	00.00	00.00
8	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (8)=(3)+(6)+(7)	00.00	00.00
9	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	00.00	00.00
10	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	00.00	00.00

Баян-Овоо сумын ИТХ-ын 2018 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

3.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

Код	Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан дүн	Бусад	Засгийн газрын хувь оролцооны нийт дүн
D01	2017 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	5,101,612.00	1,012,278.18	169,993,510.83	00.00	176,107,401.01
D02	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	00.00	00.00	00.00	00.00	00.00
D03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	5,101,612.00	1,012,278.18	169,993,510.83	00.00	176,107,401.01
D04	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт, бууралт	00.00	00.00	00.00	00.00	00.00
D05	Үндсэн хөрөнгийн өсөлт, бууралт	00.00	00.00	00.00	00.00	00.00
D06	Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз	00.00	00.00	00.00	00.00	00.00
D07	Гадаад валютын хөрвүүлэлтийн зөрүү	00.00	00.00	00.00	00.00	00.00
D08	Тайлант үеийн үр дүн	00.00	00.00	-139,440,042.29	00.00	-139,440,042.29
D09	2018 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	5,101,612.00	1,012,278.18	30,553,468.54	00.00	36,667,358.72

3.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

Эдийн засгийн ангилал	Үзүүлэлт	Өмнөх оны		Тайлант оны	
		Батлагдсан төлөвлөгөө	Гүйцэтгэл	Батлагдсан төлөвлөгөө	Гүйцэтгэл
1	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл				
2	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	47,580,700.00	47,739,700.00	49,679,900.00	48,875,510.99
21	УРСГАЛ ЗАРДАЛ	47,580,700.00	47,739,700.00	49,679,900.00	48,875,510.99
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	44,542,000.00	44,701,000.00	49,679,900.00	48,875,510.99
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	36,075,500.00	35,801,000.00	37,329,600.00	36,846,140.99
210101	Үндсэн цалин	36,075,500.00	35,801,000.00	33,729,600.00	33,723,645.95
210104	Урамшуулал	00.00	00.00	3,600,000.00	3,122,495.04
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	3,968,300.00	3,968,300.00	4,479,500.00	4,479,500.00
210201	Тэтгэврийн даатгал	3,968,300.00	3,968,300.00	2,986,200.00	2,986,200.00
210202	Тэтгэмжийн даатгал	00.00	00.00	373,300.00	373,300.00
210203	ҮОМШӨ-ний даатгал	00.00	00.00	298,700.00	298,700.00
210204	Ажилгүйдлийн даатгал	00.00	00.00	74,700.00	74,700.00
210205	Эрүүл мэндийн даатгал	00.00	00.00	746,600.00	746,600.00
2104	Хангамж, бараа материалын зардал	3,442,200.00	4,331,900.00	1,548,700.00	1,548,700.00
210401	Бичиг хэрэг	780,000.00	634,400.00	416,700.00	450,480.00
210402	Тээвэр, шатахуун	1,797,800.00	3,153,600.00	688,400.00	669,300.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	600,000.00	322,000.00	443,600.00	428,920.00
210404	Ном, хэвлэл	264,400.00	221,900.00	00.00	00.00
2105	Нормативт зардал	600,000.00	599,800.00	00.00	00.00
210502	Хоол, хүнс	600,000.00	599,800.00	00.00	00.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	00.00	00.00	4,150,000.00	3,973,920.00
210601	Багаж, техник, хэрэгсэл	00.00	00.00	2,650,000.00	2,649,900.00
210604	Урсгал засвар	00.00	00.00	1,500,000.00	1,324,020.00
2107	Томилолт, зочны зардал	00.00	00.00	1,172,100.00	1,027,500.00

Баян-Овоо сумын ИТХ-ын 2018 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

210702	Дотоод албан томилолт	00.00	00.00	1,172,100.00	1,027,500.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	456,000.00	00.00	00.00	00.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	370,000.00	00.00	00.00	00.00
210807	Газрын төлбөр	86,000.00	00.00	00.00	00.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	0.00	0.00	1000000.00	999750.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	00.00	00.00	1,000,000.00	999,750.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	3038700.00	3038700.00	0.00	0.00
2132	Бусад урсгал шилжүүлэг	3,038,700.00	3,038,700.00	00.00	00.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	3,038,700.00	3,038,700.00	00.00	00.00
	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	00.00	00.00	49,679,900.00	48,875,510.99
1320	ОРОН НУТГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	00.00	00.00	49,679,900.00	48,875,510.99
132001	Орон нутгийн төсвөөс	00.00	00.00	49,679,900.00	48,875,510.99
62	АЖИЛЛАГСАДЫН ТОО	03.00	05.00	03.00	04.00
620001	Удирдах ажилтан	01.00	01.00	01.00	01.00
620002	Гүйцэтгэх ажилтан	01.00	01.00	01.00	01.00
620003	Үйлчлэх ажилтан	00.00	02.00	00.00	01.00
620004	Гэрээт ажилтан	01.00	01.00	01.00	01.00